



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/78/НА-СТА-ТШЗ

Цахим <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он	хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512123
--	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	16

#### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Орүүлалт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ЭРХЛЭГЧ Г.ЭНХБАТ ТАНАА

2023.02.24 № 51  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 88.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>112,700,719.66</u></b>	<b><u>179,772,960.55</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	531,917.16	55,114,845.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	531,917.16	55,114,845.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	531,917.16	55,114,845.45
31211	Төрийн сангийн харилцах	3,917.16	54,586,845.45
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	528,000.00	528,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	17,461,800.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	17,461,800.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	17,461,800.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,707,002.50	124,658,115.10
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,585,098.10	69,926,931.10
35110	Тусгай зориулалттай материал	25,674,371.00	33,108,920.00
35130	Эм боох материал	17,910,727.10	36,818,011.10
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	17,151,904.40	23,841,184.00
35410	Бичиг хэргийн материал	353,500.00	722,000.00
35420	Аж ахуйн материал	5,230,900.00	5,425,600.00
35460	Хүнсний материал	35,714.40	594.00
35470	Бусад хангамжийн материал	11,531,790.00	17,692,990.00
35600	Мал амьтад	33,970,000.00	30,890,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>231,734,373.56</u></b>	<b><u>457,683,872.07</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	231,734,373.56	457,683,872.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	217,804,373.56	442,024,872.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	199,317,280.01	199,317,280.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,583,599.56	-42,111,466.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	154,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,000,000.00	-31,722,222.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,370,222.40	166,286,885.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,794,254.28	-27,255,366.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,079,310.00	25,663,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,655,739.16	-14,708,908.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,125,154.23	22,457,154.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,054,000.08	-9,902,384.84
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,930,000.00	15,659,000.00
39301	Програм хангамж	770,000.00	2,765,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-1,036,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,930,000.00	13,930,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>344,435,093.22</u></b>	<b><u>637,456,832.62</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>344,435,093.22</u></b>	<b><u>637,456,832.62</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	344,435,093.22	637,456,832.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	209,622,987.00	209,622,987.00
51101	Өмч: - төрийн	209,622,987.00	209,622,987.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-25,479,249.13	267,542,490.27

51210	Өмнөх үеийн үр дүн	-25,479,249.13	-25,479,249.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	293,021,739.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,291,355.35	160,291,355.35
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>344,435,093.22</b>	<b>637,456,832.62</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>676,842,042.59</b>	<b>874,261,762.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>493,413,752.59</b>	<b>291,294,522.48</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	120,271,352.59	291,294,522.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,271,352.59	291,294,522.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	120,271,352.59	291,294,522.48
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	373,142,400.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	373,142,400.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>183,428,290.00</b>	<b>582,967,240.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	106,447,190.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,750,790.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,696,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	47,335,800.00	56,313,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,335,800.00	56,313,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	29,645,300.00	526,654,040.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,645,300.00	526,654,040.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>643,770,752.55</b>	<b>581,240,023.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>616,020,752.55</b>	<b>573,446,649.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	616,020,752.55	573,446,649.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	311,260,013.95	308,753,964.26
210101	Үндсэн цалин	188,677,070.92	195,488,983.70
210102	Нэмэгдэл	100,011,025.11	81,031,096.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,364,990.00	4,033,000.00
210104	Урамшуулал	18,206,927.92	28,200,883.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,359,530.89	39,283,263.35
210201	Тэтгэврийн даатгал	28,834,253.41	27,343,300.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,238,600.03	3,216,858.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,496,800.22	2,465,967.06
210204	Ажилгүйдлийн даатгал	617,261.48	568,830.64
210205	Эрүүл мэндийн даатгал	6,172,615.75	5,688,306.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,396,300.00	43,250,326.41
210301	Гэрэл, цахилгаан	4,132,580.49	3,749,656.41
210302	Түлш, халаалт	37,270,519.51	37,507,470.00
210303	Цэвэр, бохир ус	1,993,200.00	1,993,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,528,158.00	37,019,132.00
210401	Бичиг хэрэг	3,702,530.00	2,974,570.00
210402	Тээвэр, шатахуун	15,476,428.00	20,963,462.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,310,000.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,164,200.00	4,924,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	875,000.00	5,846,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	144,295,375.10	82,702,087.50

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	134,025,403.50	71,523,327.00
210502	Хоол, хүнс	9,769,971.60	9,695,760.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,483,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,339,500.00</b>	<b>8,971,160.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	32,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,939,500.00	8,938,360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>376,000.00</b>	<b>956,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	376,000.00	956,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,695,940.00</b>	<b>21,096,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,695,940.00	21,096,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,769,934.61</b>	<b>31,414,615.97</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,755,300.00	1,982,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,014,634.61	29,432,415.97
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,750,000.00</b>	<b>7,793,373.59</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,750,000.00</b>	<b>4,225,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,750,000.00	4,225,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>3,567,873.59</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,567,873.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>33,071,290.04</b>	<b>293,021,739.40</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх гүйцэтгэл оны	Тайлант гүйцэтгэл оны
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>539,108,890.00</b>	<b>600,429,040.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>373,142,400.00</b>	<b>00.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>373,142,400.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	373,142,400.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>165,966,490.00</b>	<b>600,429,040.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>106,447,190.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,750,790.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,696,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>47,335,800.00</b>	<b>56,313,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,335,800.00	56,313,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,183,500.00</b>	<b>544,115,840.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,183,500.00	544,115,840.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>538,576,972.84</b>	<b>529,137,111.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538,576,972.84</b>	<b>529,137,111.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>510,826,972.84</b>	<b>521,343,738.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>311,260,013.95</b>	<b>308,753,964.26</b>
210101	Үндсэн цалин	188,677,070.92	195,488,983.70
210102	Нэмэгдэл	100,011,025.11	81,031,096.91

210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,364,990.00	4,033,000.00
210104	Урамшуулал	18,206,927.92	28,200,883.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,359,530.89</b>	<b>39,283,263.35</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,834,253.41	27,343,300.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,238,600.03	3,216,858.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,496,800.22	2,465,967.06
210204	Ажилгүйдлийн даатгал	617,261.48	568,830.64
210205	Эрүүл мэндийн даатгал	6,172,615.75	5,688,306.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,396,300.00</b>	<b>43,250,326.41</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,132,580.49	3,749,656.41
210302	Түлш, халаалт	37,270,519.51	37,507,470.00
210303	Цэвэр, бохир ус	1,993,200.00	1,993,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,158,628.00</b>	<b>35,656,132.00</b>
210401	Бичиг хэрэг	2,772,200.00	3,308,070.00
210402	Тээвэр, шатахуун	15,476,428.00	20,963,462.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,310,000.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	4,924,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	4,150,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>81,321,900.00</b>	<b>74,337,892.10</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,854,400.00	63,131,402.00
210502	Хоол, хүнс	7,967,500.00	8,268,990.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	2,937,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,339,500.00</b>	<b>12,349,860.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,802,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	609,500.00
210604	Урсгал засвар	3,939,500.00	8,938,360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>376,000.00</b>	<b>956,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>615,100.00</b>	<b>606,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,100.00	606,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>6,150,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,150,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,750,000.00</b>	<b>7,793,373.59</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,750,000.00</b>	<b>4,225,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,750,000.00	4,225,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>3,567,873.59</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,567,873.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>531,917.16</b>	<b>71,291,928.29</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>16,709,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>16,709,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>16,709,000.00</b>
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	16,709,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-16,709,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>531,917.16</b>	<b>54,582,928.29</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>531,917.16</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>531,917.16</b>	<b>55,114,845.45</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,692,987.00	134,191,054.02	-100,778,592.66	00.00	229,105,448.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,692,987.00	134,191,054.02	-100,778,592.66	00.00	229,105,448.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,762,877.89	00.00	-15,762,877.89
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	-25,479,249.13	00.00	344,435,093.22
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	-25,479,249.13	00.00	344,435,093.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	-25,479,249.13	00.00	344,435,093.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	293,021,739.40	00.00	293,021,739.40
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	267,542,490.27	00.00	637,456,832.62

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		531,917.16
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	693,463,600.00	542,278,238.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	693,463,600.00	542,278,238.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	689,238,100.00	538,052,738.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,343,600.00	308,753,964.26
210101	Үндсэн цалин	240,025,900.00	195,488,983.70
210102	Нэмэгдэл	97,521,100.00	81,031,096.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,629,100.00	4,033,000.00
210104	Урамшуулал	40,167,500.00	28,200,883.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,769,900.00	39,283,263.35
210201	Тэтгэврийн даатгал	33,163,700.00	27,343,300.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,901,500.00	3,216,858.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,121,200.00	2,465,967.06
210204	Ажилгүйдлийн даатгал	780,300.00	568,830.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,803,200.00	5,688,306.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,824,400.00	43,250,326.41
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	3,749,656.41
210302	Түлш, халаалт	42,860,400.00	37,507,470.00
210303	Цэвэр, бохир ус	4,464,000.00	1,993,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,447,200.00	35,656,132.00
210401	Бичиг хэрэг	7,863,900.00	3,308,070.00
210402	Тээвэр, шатахуун	24,414,600.00	20,963,462.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,094,100.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,924,600.00	4,924,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,150,000.00	4,150,000.00
2105	Нормативт зардал	87,813,600.00	74,337,892.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,714,800.00	63,131,402.00
210502	Хоол, хүнс	8,775,900.00	8,268,990.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,322,900.00	2,937,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,339,600.00	24,563,860.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,416,000.00
210602	Тавилга	17,600,000.00	2,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,300,100.00	609,500.00
210604	Урсгал засвар	8,939,500.00	8,938,360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	975,900.00	956,000.00
210702	Дотоод албан томилолт	975,900.00	956,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,256,100.00	5,101,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,961,100.00	606,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,295,000.00	4,495,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14467800.00	6150200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,467,800.00	6,150,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4225500.00	4225500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,225,500.00	4,225,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,225,500.00	4,225,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	693,463,600.00	600,429,040.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	62,119,400.00	56,313,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	62,119,400.00	56,313,200.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	631,344,200.00	544,115,840.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	631,344,200.00	544,115,840.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	531,917.16
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	55,114,845.45
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь “Иргэдэд чанартай, аюулгүй тэгш хүртээмжтэй нотолгоонд үндэслэсэн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн зорилгын хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, ард иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлдэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 293,021.7 мянган төгрөгөөр буюу 54.0 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	531.9	55,114.8	54,582.9
Авлага	17,461.8	-	-17,461.8
Бараа материал	94707.0	124,658.1	29,951.1
Үндсэн хөрөнгө	231,734.3	457,683.8	225,949.5
Нийт хөрөнгө	344435.1	637456.8	293021.7
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	344,435.1	637,456.8	293,021.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	344,435.1	637,456.8	293,021.7

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 54,582.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 124,658.1 мянган төгрөг болж 29,951.1 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 19,435.4 мянга, бусад хангамжийн материал 6,161.2 мянга, тусгай зориулалтын материал 7,434.5 мянга нийт 33,031.1 мянган

төгрөгөөр үлдэгдэл өссөн, мал амьтад 3,080.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 457,683.8 мянга болж 255,381.9 мянгаар өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар анхан шатны тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор ланд-76 авто машин 124,000.0 мянга, ОНХСангийн хөрөнгөөр нэн шаардлагатай туслын болон тарианы автомат шахуурга, моргийн хөргөгч, зөөлөн эд ариутгагч 21,605.0 мянга, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/502 тоот тушаал Яаралтай тусламжийн жишиг цэг 21,182.6 мянга, дархлаажуулалт вакциний зөөврийн компьютер 2,275.0 мянга, иргэний хандиваар ус цэвэршүүлэгч 160.0 мянга, Төсвийн хөрөнгөөр нэн шаардлагатай машин тоног төхөөрөмж 16,709.0 мянга, аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 72 дугаар шийдвэрээр 64 ширхэг хөрөнгийн ашиглах хугацаа болон зах зээлийн үнэлгээгээр нэмэгдүүлсэн 69,450.2 мянга, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны 467 тоот албан бичгээр 5 нэр төрлийн 1,880.0 мянга төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасаж, 67,673.6 мянга төгрөгийн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож, элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.
- Авлагын дансны үлдэгдэл 17,461.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн сайдын А/337-99 тоот тушаалын дагуу ковид-19 цар тахлаар хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөр эрүүл мэндийн даатгалаас сангаас олгогдсон байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 637,456.8 мянган төгрөг болж 293,021.7 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС -аас 507,568.9 мянга, орон нутгаас 62,119.4 төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мөн эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг 123,775.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 631,344.2 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 631,344.2 мянга, орон нутгийн санхүүжилт 62,119.4 мянга нийт 69,463.6 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 542,278.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 544,115.8 мянга, орон нутгийн санхүүжилт 56,313.2 мянга, нийт 600,429.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 3567.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 55,114.8 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 542,278.2 мянган төгрөг буюу 83.9 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл  
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
-----	-----------------------	------------	-----------	-------	---------

1	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	56,824.4	48,250.3	8,574.1	84.9%
2	80302-Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон	243,457.2	173,893.2	69,563.9	71.4%
3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	339,448.9	267,201.6	72,247.3	78.7%
4	83201-Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	5,295.0	4,495.0	800.0	84.8%
5	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хувиарласан	48,438.1	48,438.1	0	100%
<b>НИЙТ</b>		693,463.6	542,278.2	151,185.4	

*Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 141,811.2 мянган төгрөг хасагдсан байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 643,770.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,656.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад тээвэр шатахууны зардал 5,487.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, гэрэл цахилгаан зардал 535.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>3</sup> заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг гүйцэтгэсэн. Аудитаар үндсэн хөрөнгийн тулгалт хийгдсэн бөгөөд Төрийн

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

<sup>3</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.1, НББ-ийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.2.1 дэх заалтын дагуу эд хөрөнгийн тооллогын комисс томилогдож, эд хөрөнгийн тооллого хийжээ.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2		100
Нийт дүн	2		2		100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,159.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,279.7 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрч төлбөрийн акт тогтоож, 9,880.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчил дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нарын 11,12 сарын илүү цагийн хөлсийг 2,867.700 төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.5<sup>5</sup>, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2<sup>6</sup> дугаар хавсралтад заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Албан хаагч нарт 1,412.000 төгрөгөөр биеийн тамирын хувцас худалдан авч өгсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>7</sup> дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 9,880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөнд албан шаардлага өгөв.

5.2.2 Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>9</sup> заасныг зөрчсөнд албан шаардлага өгөв.

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>5</sup> Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно.

<sup>6</sup> Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно.

<sup>7</sup> Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно

<sup>8</sup> Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

<sup>9</sup> Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

